



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРААС ОЛГОЖ БУЙ
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН
/ДОА-2018-01-ГА/**



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас олгож буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Чойбалсан хот

2018 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын алба

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584207

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа
Утас: 70584207

Аудитор
М.Ухаанбилэг,
Я.Зориг

2018 оны 06 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын утас,
70584203 дугаарын
факсаар харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. Төсөл, хөтөлбөрүүдийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаагүй байна.

- 1.1. Төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг удирдамжийн дагуу зохион байгуулаагүй байна.
- 1.2. Зарим хөтөлбөрүүд хэрэгжээгүйгээс санхүүжилт буцаагдсан байна.
- 1.3. Төсөл, хөтөлбөрүүдийн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

II Бүлэг. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөө бага, үр дүнг бодитой үнэлэхгүй байна.

- 2.1. Төсөл хөтөлбөрөөр олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулаагүй байна.
- 2.2. Мэдээ, тайлангийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлээгүй байна.
- 2.3. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй байна.

ДҮГНЭЛТ
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ
САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР
ЗӨВЛӨМЖ
ТӨЛБӨРИЙН АКТ
ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол Улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААН	Аж ахуйн нэгж
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХБХЭУЧОХ	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
АБДХ	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
ЗХЭГБДХ	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
МХЭДХ	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
ХБИАБДХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
АМЗҮХХ	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2018 оны А/06 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас олгож буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.

- Төсөл, хөтөлбөрүүдийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан эсэх,
- Төсөл, хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг бодитой үнэлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 2017 онд олгосон төсөл, хөтөлбөрүүдийн мэдээ тайлан, дотоод болон хөндлөнгийн хяналт хийсэн баримт, бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл:

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас 2017 онд “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-үүдийг хэрэгжүүлэхэд нийт 1131,7 сая төгрөгийн төсөв батлагдаж 1073,9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллажээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхан шатны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /4.1.1/
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд”
- Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”
- Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”
- Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны А/63 дугаар

тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн холбогдох бичиг баримт”

- *Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.*

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор М.Ухаанбилэг, Я.Зориг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр эхэлж 06 дугаар сарын 29-ний өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 2 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

I Бүлэг. Төсөл, хөтөлбөрүүдийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаагүй байна.

1.1. Төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг удирдамжийн дагуу зохион байгуулаагүй байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 2017 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 6 хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Уг хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор баталсан байна.

Хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэд, ажил олгогчийн сонгон шалгаруулалтыг шалгахад дараах байдалтай байна.

- **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-үүдийн** эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох, бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгүүдийг байгуулж төслүүдийг сонгон шалгаруулсан гэх боловч, шалгаруулалт зохион байгуулсан ажлын баримт, төслүүдийг эрэмбэлэн үнэлсэн үнэлгээний хуудас, бусад нотлох баримтуудыг аудитын явцад бидэнд ирүүлээгүй. Иймээс сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.
- **“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох**

хөтөлбөр”-ийн хүрээнд 3 төрлийн сургалт зохион байгуулсан байна. Сургалт явуулах байгууллагыг ХХҮЕГ-т шалгаруулдаг бөгөөд 2017 онд уг тендерт шалгарсан “Дорнод талын хөтөч”, “Оюуны ундраа” ТББ-ууд ХХҮГ-тай гэрээ байгуулан аж ахуй эрхлэх ур чадвар олгох, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрт бэлтгэх сургалтуудыг хийсэн байна.

- **“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”**

- “Борлуулалтын дэмжлэг”-г Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн олгохоор заасан байна. Холбогдох ажлын баримтуудыг үзэхэд хүсэлт ирүүлсэн бүртгэл байхгүй байгаа бөгөөд ХХҮГ-ын ажилтнууд төсөл авсан иргэдтэй утсаар холбогдож, үзэсгэлэн худалдаанд оролцох боломжтой гэсэн 10 иргэнийг сонгосон гэсэн ч төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдтэй утсаар холбогдсон, иргэдэд тэгш боломж олгосон эсэхийг нотлох баримт байхгүй байна.
- “Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт”-г Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдээс ХХҮГ-ын мэргэжилтнүүд 12 сарын турш түрээс төлсөн шалгуурыг хангасан 9 хүнийг сонгон 6,8 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн гэх боловч хүсэлт ирүүлсэн иргэдийн бүртгэл байхгүй байгаа нь сонгон шалгаруулалт хэрхэн хийгдсэнийг тодорхойлж дүгнэх боломжгүй байна.
- “Нийтийг хамарсан ажил”-д ХХҮГ-т ажилгүй, ажил идэвхитэй хайж буй иргэнээр бүртгүүлсэн 375 иргэнийг 2017 онд оролцуулсан байна. Аудитаар нийт хамрагдсан иргэдийн 75,0 хувийг түүвэрт хамруулж ХХҮГ-т бүртгүүлсэн иргэн мөн эсэхийг үзэхэд бүгд ажилгүй, ажил хайж буйгаар бүртгэлтэй иргэд байна.

- **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”**

Дээрх хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 3 төрлийн сургалт, 6 төрлийн хөнгөлөлт, урамшуулал, дэмжлэг олгохоор төлөвлөсөн байна.

- Аж ахуй эрхлэх ур чадвар олгох, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрт бэлтгэх сургалтуудыг 2017 онд тендерт шалгарсан “Дорнод талын хөтөч”, “Дорнын амжилт сургалтын төв”, “Талын сувдан гүүр” ТББ-уудтай гэрээ байгуулан хүсэлт ирүүлсэн иргэдийг хамруулан зохион байгуулсан байна.
- Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч нарт ажилласан цагийг тооцон урамшуулал олгодог боловч 2017 онд иргэдээс хүсэлт ирээгүй тул олгогдоогүй гэсэн тайлбар өгсөн бөгөөд зорилтот бүлэгт хөтөлбөрийн үйл ажиллагааг таниулах ажлын үр дүн муу байна.
- Борлуулалтын дэмжлэг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, ажил олгогчийн урамшуулал, санхүүгийн дэмжлэгийн хөтөлбөрүүдийн хувьд сонгон шалгаруулалт нь удирдамжид заасан шалгууруудыг хангаж байна.

- **“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”**

Дээрх хөтөлбөрийн хүрээнд залуучуудад 1 төрлийн сургалт, 4 төрлийн хөнгөлөлт, дэмжлэг олгохоор төлөвлөсөн байна.

- Аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалтыг “Дорнод талын хөтөч” ТББ-тай гэрээ байгуулан, сургалтад хамрагдах хүсэлт ирүүлсэн залуучуудыг хамруулан зохион байгуулсан байна.

- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг хэрэгжүүлэхээр ХХҮГ-ын 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/15 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан байна. Уг хөтөлбөрийн сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл болон ажлын баримттай танилцахад төсөл хүлээн авах зарыг 2017 оны 05 дугаар сарын 17-30-ны өдрийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж 15-24 насны мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн 23 бүлгийн 40 төгсөгчийн төслийг хүлээн авч шалгаруулалтаар 100,0 хувийн саналаар шалгаруулсан нь хөтөлбөрийн удирдамжид заасан шалгуурыг хангасан байна.
- Гарааны бизнес эрхлэхийг дэмжих хөтөлбөрийг удирдамжид заасан 15-34 насны залуучуудад аж ахуй эрхлэлт, гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх зөвлөгөөг бүлгүүдийн хэрэгцээ, хүсэлтэд үндэслэн ХХҮЕГ-аас “гарааны бизнесийг дэмжих, бизнес инкубатор төвийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй” “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран шалгуурын дагуу үнэлж шалгаруулсан байна.
- Борлуулалтын дэмжлэгт борлуулах цэг болон үзэсгэлэн худалдааны түрээсийн төлбөрт ирүүлсэн хүсэлтийг үндэслэн үнэлгээ хийж ажлын байраар хангадаг байна. Шалгуурыг хангасан 3 иргэнийг уг дэмжлэгт хамруулсан байна.
- Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдэд түрээсийн гэрээ, төлбөр төлсөн баримтыг үндэслэн нөхөн олгодог байна. Уг хөтөлбөрийн хувьд 2017 онд хүсэлт ирээгүй нь удирамжид заагдсан шалгуур өндөр байдагтай холбоотой байна.

● **“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”**

ХХҮГ-ын 2017 оны А/35а тушаалаар малчин өрхөд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан байна.

Малчин өрхүүдийг хөтөлбөрт хамруулах арга хэмжээг зохион байгуулахдаа сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 5 хүртэлх малчин өрхийг сонгон шалгаруулж ажилласан байна.

Сонгон шалгаруулалтад хөтөлбөрийн 3.1¹-д заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажилласан боловч малын тоог бог малд шилжүүлсэн тооцооллыг алдаатай хийсэн тохиолдлууд гарсан байна.

Тухайлбал Чулуунхороот, Чойбалсан, Хөлөнбуйр, Баян-Уул сумаас бусад 10 сумдын 34 өрхөд дээрх тооцооллын алдаа гарсан бөгөөд үүнээс 24 иргэний тооцоолол байгаа нь хөтөлбөрийн 2.2.2²-д заасан шалгуурын 4,0 сая, 5,0 саяын шалгуураас даваагүй, 10 иргэний тооцооллыг зөрүүтэй тооцсоноор (үүнд: 3 иргэн 5,0

¹ “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 3.1 дэх заалт: 3.1.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүд, олгосон малын тоо, төрлөөр, арга хэмжээнд хамрагдсанаас хойш 24 сарын дараах малын тоо, орлогын дүнгээр, 3.1.2. Шавь сургалтад хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүдийн тоо, хүйсээр, шавь сургалт хийсэн дадлагажуулагч малчны тоо, 3.1.3. Мал аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хамрагдсан малчин өрх, өрхийн гишүүдийн тоо, хүйсээр, 3.1.4. Туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдсан малчин өрхийн тоо, гишүүдийн тоо

² “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2.2.2 дэх заалт: Арга хэмжээнд хамрагдах малчин өрх нь 150 хүртэл толгой малтай бол 5.0 сая төгрөг, 150-200 хүртэл толгой малтай бол 4.0 сая төгрөгийн мал худалдан авах арга хэмжээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна.


сая, 2 иргэн 4,0 сая төгрөгийн дэмжлэгт нийцсэн, 5 иргэн 200-аас дээш малтай байсан байна.) мөнгөн дэмжлэгийн хэмжээ зөрүүтэй олгогдсон байна.

1.2 Зарим хөтөлбөрүүд хэрэгжээгүйгээс санхүүжилт буцаагдсан байна.

Хөтөлбөрүүдийн төсвийг ХХҮЕГ-ын даргын 2017 оны А/39, А/303 тоот тушаалуудаар баталсан бөгөөд гүйцэтгэл нь дараах байдалтай байна.

Дүрслэл №1.

/сая.төг/



Нийт 6 хөтөлбөрт 2017 онд нийт 1131,7 сая төгрөг батлагдаж 1073,9 сая буюу 94,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

- **“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр”**

Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ, үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалтад нийт 271 хүн хамрагдаж 31,6 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд сургалтад хамрагдсан иргэдийн тоо төлөвлөгөөнөөс 10,7 хувиар давж, харин санхүүжилтийг 13,7 хувиар хэмнэж ажилласан байна.

- **“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”**

АБДХ-т нийт 483,3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 451,6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Цагийн ажилд зуучлах арга хэмжээнд хөрөнгө огт төлөвлөөгүй нь уг үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой байна.

- **“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр” “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-үүдийн** дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ санхүүжигдээгүй, борлуулалтын дэмжлэг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, ажил олгогчийн урамшуулал, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын зардлууд хэмнэгдсэн байна. Шалтгааныг тодруулахад төслийн шалгуур хангадаггүй, хүсэлт ирүүлдэггүйтэй холбоотой гэж тайлбар өгсөн ч иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулах талаар мэдээлэл, сурталчилгаа хийсэн гэх нотолгоо байхгүй байна.

- **“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”**

Хөтөлбөрт 2017 онд нийт 110,0 сая төгрөг батлагдаж 106,6 сая буюу 96,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Борлуулалтын дэмжлэг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөөс бусад хөтөлбөрүүд бүрэн санхүүжигдсэн байна.

Борлуулалтын дэмжлэгийг хүсэлт ирүүлсний дагуу “Цахиурт гранд” ХХК-д олгосон нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй бөгөөд ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд санхүүжилт олгогдоогүй байна. Энэ нь залуучуудын хувьд хөтөлбөрийн шалгуур өндөр байдагтай холбоотой байна.

- **“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”**

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 29,4 сая, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт /төсөл/ 25,0 сая, нийт 54,4 сая төгрөгийг олгохоор баталж, 100,0 хувь санхүүжүүлсэн байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт зааснаар 2017 онд дунджаар 1 ахмад мэргэжилтэнд 80 цагаар тооцож нийт 105 ахмад мэргэжилтэнд урамшуулал олгохоор төлөвлөсөн байна. Тайлант онд 69 ахмадад урамшуулал олгогдсон нь 1 ахмад мэргэжилтэнд ногдох ажилласан цаг төлөвлөсөн хэмжээнээс 30-40 цагаар нэмэгдсэнтэй холбоотой байна. Энэ нь хөтөлбөрийн 4.4³-д заасан хэмжээнээс хэтрээгүй байна.

- **“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”**

Малчин өрхүүдийг малжуулах хөтөлбөрт 305,0 сая төгрөг, сургалт, зөвлөгөөнд 14,6 сая төгрөг, нийт 319,6 сая төгрөгийг баталсан байна. Үүнээс 319,4 сая төгрөгийг санхүүжүүлж, гүйцэтгэл 99,9 хувьтай байна. Сургалтын зардалд 14,4 сая төгрөг зарцуулсан нь уг хөтөлбөрт олгосон санхүүжилтийн 4,5 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь журмын 2.3.1⁴ дэх заалтыг хангасан байна.

Малчин өрхийг малжуулах хөтөлбөрийн хувьд 4,0 сая төгрөгийн шалгуурыг хангасан малчин өрхийн тоо, 5,0 сая төгрөгийн шалгуурыг хангасан малчин өрхийн тооноос их байснаас шалтгаалж төлөвлөснөөс 8 өрхөөр нэмэгдэж, илүү олон өрх уг хөтөлбөрт хамрагдах үндэслэл болсон байна.

1.3 Төсөл, хөтөлбөрүүдийн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор

³ “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 4.4 дэх заалт: Зөвлөх мэргэжилтний төслийн хүрээнд олгох урамшууллыг тооцохдоо нэг жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр буюу нийт 240 цагаас хэтрэхгүй байхаар төсөл, холбогдох гэрээнд тусган ажиллана.

⁴ “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2.3.1 дэх заалт: Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн болон малын эрүүл мэнд, мал маллах арга ажиллагааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалт /мах, сүү цагаан идээ, ноос, арьс шир боловсруулах г.м/, туршлага солилцох уулзалт зохион байгуулах, малын хашаа, хороо барих, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг, туслалцаа үзүүлэх бөгөөд энэхүү арга хэмжээний нийт зардал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэхүү хөтөлбөрт хуваарилсан нийт хөрөнгийн 5 хувиас ихгүй байна.

батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд”-д тус бүрийн хүрэх үр дүнг тодорхойлсон байна.

- **“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр”-ийн хүрэх үр дүн:**

1. Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний үр дүн сайжирсан байна;
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна;
3. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан иргэд ажлын байраар хангагдсан байна;
4. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн, ажилгүй байх хугацаа богиноссон байна.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөрт төлөвлөгөөний дагуу 242 иргэн хамрагдахаас гүйцэтгэлээр 271 иргэн хамрагдаж чадамжийн гэрчилгээ, мэргэшсэн үнэмлэх зэрэг албан ёсны бичиг баримттай болсон байна. Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан 20 иргэн ажлын байртай бөгөөд зөвхөн мэргэжлийн үнэмлэх авах зорилготойгоор сурч төгссөн байна. Ажил олгогчдоос ирүүлсэн хүсэлт болон халагдах мэдэгдлийн дагуу давтан болон мэргэжлийн, үйлдвэрлэл дээрх сургалтуудад хамруулснаар тухайн иргэд ажлын байрандаа хэвээр байна.

- **“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрэх үр дүн:**

1. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж ажлын байр бий болсон байна.
2. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдан үйл ажиллагаа тогтворжсон байна.
3. Ажил олоход хүндрэлтэй иргэд байнгийн ажлын байраар хангагдаж, орлого нэмэгдсэн байна.
4. Иргэд түр ажлын байраар хангагдаж, орлого нэмэгдсэн байна.

- **“Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг”**

Уг төслөөр 73 иргэнд 210,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгож 73 ажлын байр бий болсон гэж тайлан мэдээнд дурьдсан байна. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилын дүнд эдгээрээс огт хэрэгжээгүй 3, насны шалгуур хангахгүй 2, тодорхойгүй 8, зогсонги байдалтай 5, төрийн албанд ажилд орсноос төсөл хэрэгжүүлэх боломжгүй болсон 2 төсөл арга хэмжээ байгаа нь нийт ажлын байрын 27,6 хувийг эзэлж байна. Энэ нь тухайн зорилтот түвшнийг 100,0 хувь хангасан гэж мэдээлсэн тайлангаас зөрүүтэй байна.

- **“Аж ахуй эрхлэлтийн сургалт”**

Сургалтад 211 иргэн хамрагдсан байна. Хамрагдсан иргэд гэрчилгээтэй болсон бөгөөд тухайн онд төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийг хамруулсан байна.

- **“Буцалтгүй нэг удаагийн тусламж-Борлуулалтын дэмжлэг, Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт”**

ХХҮГ-аас олгосон төсөл хөтөлбөрт хамрагдсан 10 иргэнд Дорнод худалдаа, ЕХРО ХХК-уудтай гэрээ байгуулан 4 лангуу түрээслэн ажилласан байна. Аудитын явцад хөтөлбөрт хамрагдсан иргэдээс утсаар тайлбар, тодруулга авах горим сорил хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг авсан иргэд үйл ажиллагаа хэвийн тогтворжсон байна.

Түрээсийн хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн бүртгэл, мэдээлэл байхгүй байна. Мөн түрээсийн хөнгөлөлтөд иргэдийн хамрагдалт төлөвлөгдсөн

түвшиндээ хүрээгүй 27 хүнд олгохоор төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 9 хүнд олгосон нь зорилтот түвшнээс 66,7 хувиар бага байна. Ажил олгогч 12 ААН-тэй гэрээ байгуулсан ч ажилгүй иргэдийг 12 сарын турш ажиллуулах, гэрээний шаардлагыг биелүүлээгүй тул зорилтодоо бүрэн хүрээгүй байна. Шаардлага хангаж ажилласан 4 ААН-д буюу 33,3 хувьд нь урамшууллыг олгосон байна.

○ *“Нийтийг хамарсан ажил”*

Нийтийг хамарсан ажилд 210 иргэнийг түр ажлын байраар хангахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 374 иргэнийг хамруулсан байна. Хамрагдсан иргэдээс түүвэрлэн ХХҮГ-ын нэгдсэн мэдээллийн санд регистрийн дугаараар шалгахад ажилгүй, ажил идэвхитэй хайж байгаа иргэнээр бүртгэлтэй байна.

• **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрэх үр дүн:**

- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр нэмэгдсэн байна.*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуй, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.*

Тус хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, ажил олгогчийн урамшуулал, дэмжлэгт нийт 31 ажлын шинэ байрыг бий болгосон, хөдөлмөрт бэлтгэх болон аж ахуй эрхлэлтийн сургалтад 144 иргэн хамрагдсан гэж аймгийн ХХҮГ-ын 2017 оны жилийн эцсийн тайлан, ХХҮЕГ-т хүргүүлсэн тайланд тус тус тайлагнасан байна.

Аудитын явцад бид хөтөлбөрийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж танилцан санхүүгийн дэмжлэг авсан иргэд, ажил олгогчидтой уулзаж судалгаа авах, утсаар холбогдож лавлагаа авах зэрэг горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд 31 иргэнд олгосон дэмжлэгээс 25 иргэн нь үйл ажиллагаа явуулж, 5 хүн тодорхойгүй, 1 хүний үйл ажиллагаа зогссон байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд бий болсон ажлын байр 80,6 хувьтай байгаа тул зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна гэж дүгнэж байна.

Хөдөлмөрт бэлтгэх болон аж ахуй эрхлэлтийн сургалтад нийт 144 иргэн хамрагдаж чадамжийн гэрчилгээ авсан байна.

• **“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрэх үр дүн:**

○ *Залуучуудын аж ахуй, бизнес, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байх.*

Тус хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 42 иргэн хамрагдаж 100,0 сая төгрөгийг зарцуулж 42 ажлын шинэ байрыг бий болгосон, аж ахуй эрхлэлтийн сургалтад 101 иргэнийг хамруулсан гэж аймгийн ХХҮГ-ын 2017 оны жилийн эцсийн тайлан болон ХХҮЕГ-т хүргүүлсэн тайланд дурьдсан байна.

Нийт 42 хүнд санхүүгийн дэмжлэг олгосоноос 27 хүн нь үйл ажиллагаа явуулж, 12 хүн тодорхойгүй, 3 хүн ажиллахгүй байна.

Хөтөлбөрийн хүрээнд бий болсон ажлын байр 64,3 хувьтай байгаа нь аймгийн ХХҮГ-ын тайлангаас зөрүүтэй байгаа бөгөөд зорилтот түвшин бүрэн хангагдаагүйг харуулж байна.

Аж ахуй эрхлэлтийн сургалтад 101 иргэн хамрагдаж батламжийн гэрчилгээг авсан бөгөөд энэхүү гэрчилгээг авснаар дараагийн төсөл, хөтөлбөрт оролцох давуу эрхтэй болсон байна.

- **“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрэх үр дүн:**

- Ахмад мэргэжилтэн нь ажлын байраар хангагдаж, орлого нэмэгдсэн байна.
- Ахмад мэргэжилтний мэдээллийн сан бий болсон байна.
- Ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.

ХХҮГ-ын 2017 оны тайланд тусгагдсанаар хөтөлбөрт 79 ахмад мэргэжилтнийг хамруулж, 79 ажлын байр бий болсон гэж тайлагнасан ч аудитын явцад бид ажиглалт, судалгаа, тулган баталгаажуулалтыг хийсэн бөгөөд 69 түр ажлын байр, 7 байнгын ажлын байр бий болсон байна.

Дэвшүүлсэн зорилтын хүрээнд ажлын байраар хангагдаж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн гэж үзэж болох ч 3-р зорилт буюу ахмад мэргэжилтний мэдээллийн сан бий болгох зорилт хэрэгжээгүй байна.

- **“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрэх үр дүн:**

- Малжуулах арга хэмжээнд залуу малчид хамрагдаж, амьжиргаа нь дээшилсэн байна.
- Туршлага солилцох уулзалт болон сургалтуудыг зохион байгуулснаар ахмад, туршлагатай малчдаас суралцаж, мал маллах арга ажиллагааны чадвар, мэдлэг, дээшилсэн байна.

Тайланд тусгагдсанаар залуу малчин, цөөн малтай иргэдэд мал маллагааны арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх үр чадвар олгох, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, туршлага судлах, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 69 малчин өрхийг хамруулж, 69 ажлын байрыг бий болгосон байна.

Аудитын явцад бид малжуулах хөтөлбөрийг газар дээр нь үзэж танилцан тулгалт, судалгаа, ярилцлага хийх зэрэг горимуудыг гүйцэтгэхэд малчин өрхүүд тус хөтөлбөрт хамрагдсанаар амьжиргаа нь дээшилж, малын тоо толгой нь өссөн байна.

Аудитын явцад бид ХЭДС-аас 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж танилцан санхүүгийн дэмжлэг авсан иргэд, ажил олгогчидтой уулзаж судалгаа авах, утсаар холбогдож лавлагаа авах, түүвэрлэн үзэх зэрэг горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд нийт 296 байнгын ажлын байр бий болохоос 252 ажлын байр бий болж ерөнхий үнэлгээ 85,1 хувьтай байна.

II Бүлэг. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөө бага, үр дүнг бодитой үнэлэхгүй байна.

2.1 Төсөл хөтөлбөрөөр олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулаагүй байна.

Нийт 6 хөтөлбөрт 2017 онд нийт 1131,7 сая төгрөг батлагдсанаас 1073,9 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 57,8 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

- **“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр”**

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөрт 2017 онд нийт 31,6 сая төгрөгийг зарцуулснаас хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд 6,5 сая,

үйлдвэрлэл дээрх сургалтад 10,0 сая, мэргэжлийн болон давтан сургалтад 15,1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Сургалтуудыг “Дорнод талын хөтөч”, “Оюуны ундраа” ТББ-ууд хийж төлбөрийг шилжүүлсэн байна. Гэрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ирүүлж байхаар тусгасан ч санхүүгийн тайланг ирүүлээгүй байгаа нь гэрээний биелэлтийг бүрэн хангуулж ажиллахгүй байгааг харуулж байна.

- **“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”**

- **“Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг”**

Уг төслөөр 210,0 сая төгрөг зарцуулагдсан байна. Үүнээс аудитын явцад хэрэгжүүлсэн горимуудын дүнд үйл ажиллагаа явуулж эхлээгүй, цаашид хэрэгжих боломжгүй болсон, шалгуур хангаагүй, тодорхойлох боломжгүй, үр дүнгүй 20 төсөлд 58,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь нийт төслийн 27,6 хувийг эзэлж байна.

- **“Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт”**

Сургалтыг шалгарсан Дорнод талын хөтөч ТББ явуулсан байна. Санхүүжилтийн зарцуулалтын тайланг ирүүлэхээр гэрээнд тусгасан ч зөвхөн үйл ажиллагааны тайлан авч төсөл хөтөлбөрт хамрагдсан 211 хүний сургалтын зардал 6,0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

- **“Борлуулалтын дэмжлэг, Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт”**

Борлуулалтын дэмжлэгт 10 иргэнийг хамруулж 6,0 сая төгрөгийг түрээсийн төлбөрт шилжүүлсэн байна. Аудитын явцад дэмжлэгт хамрагдсан иргэдтэй утсаар болон биечлэн уулзаж ярилцлага тодруулга авахад үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцон тодорхой үр дүн гарсан тухайгаа ярьж байсан. Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийг түрээслэгчтэй байгуулсан гэрээний дагуу түрээсийн төлбөрөө 12 ба түүнээс дээш сар төлсөн баримтыг үндэслэн тухайн иргэний дансанд шилжүүлдэг байна. Тайлант онд 9 иргэнд 6,8 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт эдлүүлсэн байна.

Аудитын явцад анхан шатны баримтыг үзэхэд түрээслэгчтэй байгуулсан гэрээ, хөнгөлөлт эдлэх өргөдөл байхгүй 1 иргэнд 0,8 сая төгрөгийн түрээсийн гэрээний хөнгөлөлт эдлүүлсэн нь баримтын бүрдэл бүрэн хангаагүй иргэнийг санхүүжүүлсэн байна.

- **“Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах”**

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалахад 39,8 сая төгрөгийг зарцуулсан. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөс ажилгүй иргэдийг хамруулах чиглэлийг өгсөн байна. Хүнсний ногоо тариалсан иргэдээс үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж ХХҮГ-т ирүүлэхээр гэрээнд тусгасан ч хэрэгждэггүй байна. Төсөл хэрэгжүүлэгчийн ажлын явц болон үр дүнгийн талаар нотлох баримт байхгүй тул санхүүжилтийг зориулалтын дагуу олгосон эсэхийг үнэлэх боломжгүй байна. Хэрлэн суманд ногоо тарих иргэдэд ажлын багаж, ногооны үрсэлгээ зэрэгт 17,0 сая төгрөгийг зарцуулж, бусад сумдад 22,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

- **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”**

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т шалгарсан төслүүдийг хэрэгжүүлэгч 16 иргэний одоогийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, хэрэгжилтэд үнэлгээ хийхэд өрхийн үйл ажиллагааг зориулалтын дагуу явуулж байгаа 30,0 сая төгрөгийн дэмжлэг авсан 10 иргэн байна.

Үйл ажиллагаа нь тогтворжсон эсэх нь тодорхойгүй 15,0 сая төгрөгийн дэмжлэг авсан 5 иргэн, үйл ажиллагаа нь зогсож 3,0 сая төгрөгийн дэмжлэг авсан 1 иргэний санхүүжилтийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, ажил олгогчийн урамшуулал, дэмжлэгт нийт 15 иргэнд 52,9 сая төгрөгийг олгож санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

Нийт олгосон санхүүжилтийн 17,8 хувийг төсөлд хамрагдсан хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэд зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

- **“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”**

Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийн хувьд 70,0 сая төгрөгийн санхүүжилт авсан 27 иргэн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тухайн ондоо хэрэгжээд дараа жилээс үйл ажиллагаа нь зогссон 6,0 сая төгрөгийн дэмжлэг авсан 3 иргэн, үйл ажиллагаа нь тогтворжсон эсэх нь тодорхойгүй 24,0 сая төгрөгийн дэмжлэг авсан 12 иргэн байна.

Борлуулалтын дэмжлэгт хамрагдаж 3,6 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон 3 төслийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж байна.

Нийт олгосон санхүүжилтийн 29,0 хувийг төсөлд хамрагдсан залуучууд зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

- **“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”**

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 2017 онд нийт 54,4 сая төгрөгийг зарцуулснаас 25,0 сая төгрөгийг 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй төсөлд, 29,4 сая төгрөгийг зөвлөх үйлчилгээнд тус тус зарцуулсан байна.

Эргэн төлөгдөх нөхцөлтэй төслийн хувьд 10 төсөл хэрэгжихээс зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа 7 төсөл, арга хэмжээ байна. Үйл ажиллагаа нь зогссон, цаашид хэрэгжих боломжгүй болсон 3 төсөл, арга хэмжээнд нийт 7,5 сая төгрөгийг олгосон нь нийт санхүүжилтийн 30 хувийг эзэлж байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ байгаа ч ашиг орлого буурснаас зогсоосон гэсэн шалтгаантай төсөл арга хэмжээ байгаа нь төслийг сонгон шалгаруулахдаа тооцоо судалгаанд үндэслээгүйтэй холбоотой байна.

- **“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”**

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2017 онд нийт 305,0 сая төгрөгийг зарцуулж, гэрээнд заасан малыг нийлүүлсэн нь төсөлд хамрагдсан иргэдийн хүсэлтэд нийцсэн байна. Малчин өрхийн мал хүлээж авсан актыг үндэслэн аймгийн ХХҮГ-аас санхүүжилтийг нийлүүлэгч талд шилжүүлж ажилласан байна.

Аудитын явцад бид малчин өрхүүдтэй уулзах, утсаар холбогдож лавлагаа авах, мал хүлээн авсан актыг гэрээтэй тулган баталгаажуулах зэрэг горимуудыг хийхэд санхүүжилтийг 100 хувь олгож, малчин өрхүүдэд малыг бүрэн хүлээлгэн өгсөн байна.

Малыг малчин өрхөд нийлүүлэхдээ тухайн сумын үнэ ханшаар худалдан авдаг ба сум бүр харилцан адилгүй үнэ ханштай байна.

Тухайлбал: Сумдад төлөг 50,0-80,0 мянган төгрөг, борлон 25,0-80,0 мянган төгрөг, бяруу, шүдлэн 260,0-600,0 мянган төгрөг, тугалтай үнээ 750,0-800,0 мянган төгрөгийн үнэтэй байна. Халхгол, Хэрлэн, Баянтүмэн сумдад малын үнэ ханш зах зээлийн ханшнаас илүү өндөр байна.

Залуу малчдын сургалт, туршлага солилцох уулзалт, зөвлөгөөнд 14,4 сая төгрөгийг зарцуулж, зочид буудал, хоолны зардалд 68 хувь, шатахуун, унааны

зардалд 27 хувь, сургалтын зардалд 5 хувийг тус тус зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнд байна.

Гэрээнд заасан хугацаанд төслийн хэрэгжилтийн явцын тайланг хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэд ХХҮГ-т ирүүлдэггүй байна.

Нийт 2017 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдээс 44 иргэн 113,5 сая төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.2 Мэдээ, тайлангийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлээгүй байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн 1.5-д “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийн сарын тайлан, мэдээг дараа сарын 03-ны дотор, улирлын тайлан, мэдээг дараа улирлын эхний сарын 03-ны дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт, тус газар нь тайлан, мэдээг ажлын 3 хоногт багтаан нэгтгэн дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлнэ.”, 1.6-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний болон хамрагдаж буй иргэдийн мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (LMIS)-д маягтын дагуу тогтмол бүртгэж шинэчилнэ” гэж тус тус заасан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн мэдээ тайлан, түүний үр дүнг удирдамжинд заасан хугацаанд нь ХХҮГ-т хүргүүлж ажилласан ч мэдээ, тайлан зөрүүтэй байна. (Бий болсон ажлын байр)

ХХҮГ-ын даргын 2017 оны А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу төсөл, хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийн мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

2.3 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх дотоод болон хөндлөнгийн хяналт нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32.2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.”, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн 1.2 “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл болон сум, дүүрэг /хорооны Засаг дарга, иргэдийн төлөөллийн байгууллага байнгын хяналт тавина.”, 1.4 “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт-үнэлгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам жилд 1 удаа хийнэ.”, ХХҮГ-ын дотоод хяналт шалгалтын журмаар тус тус зохицуулагджээ.

МУ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.1, 28.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 03-р сарын 16-ны өдрийн А/116 тоот захирамжаар хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг шинэчлэн баталж зөвлөлийн 2017 оны 01 тоот тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөг баталсан байна. Тус зөвлөлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралтын 7-д хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн явц байдалд хяналт, үнэлгээ

хийж дүгнэлт гаргах гэж заасан боловч 2017 онд хуралдсан 4 удаагийн хурлын тэмдэглэлд хяналт хийсэн талаар мэдээлэл байхгүй байна.

ХХҮГ-ын дотоод хяналт шалгалтын журмын дагуу тус газрын 2017 онд хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулсан төслүүдийн хэрэгжилтэд 5 удаагийн дотоод хяналтыг хийсэн ч төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй, санхүүгийн дэмжлэг авсан иргэд гэрээнд заасан төслийн хэрэгжилтийн тайлан мэдээг ирүүлдэггүй, сургалтын чанар, үр дүнд дотоод хяналт хийгдсэн эсэх нь тодорхойгүй, хяналт хийснээр ямар арга хэмжээ авч төсөл хөтөлбөрийн үр дүнг сайжруулсан нь баримтаар нотлогдохгүй байна.

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн төлөлтийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны байдлаар гаргахад “Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт”-т хамрагдсан 73 иргэдээс эргэн төлөлт 55 иргэний 37,1 сая төгрөгөөр дутуу, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 16 иргэдээс 7 иргэн 2,7 сая төгрөг дутуу, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 23 бүлгийн иргэдээс 16 иргэн 10,1 сая төгрөг дутуу, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-т хамрагдсан 10 иргэдээс 6 иргэний 1,7 сая төгрөгийн эргэн төлөлт дутуу, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан 69 иргэдээс 12 иргэний 11,9 сая төгрөгийн эргэн төлөлт дутуу бөгөөд нийт 193 иргэнээс 96 иргэн 58,5 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

Энэ нь дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн төлөлтийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны байдлаар гаргахад явж байна.

Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас олгосон Залуу малчин хөтөлбөрийн 2014 оны 45,3 сая төгрөг, 2015 оны 51,0 сая төгрөгийн дэмжлэгийн эргэн төлөх хугацаа нь хэтэрсэн байна. Уг үлдэгдлээс 2018 онд 10,5 сая төгрөг эргэн төлөгдөж 85,6 сая төгрөг үлдсэн байна.

Иймд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр иргэдэд олгосон боловч, хугацаандаа төлөгдөөгүй 85'585'000 төгрөгийн үлдэгдлийг Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аймгийн МХГ нь 2017 онд хөдөлмөр эрхлэлтийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 2015-2016 онуудад эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг аваад хугацаандаа төлөөгүй 77 иргэний 55,9 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон байна. ХХҮГ нь авлагын үлдэгдэл 44,6 сая төгрөгийг төлүүлэхээр шүүхэд хандахаар бэлтгэл ажлыг хангасан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төсөл, хөтөлбөрүүдийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаагүй байна.
2. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлийг зөрүүтэй мэдээлж, үр дүнг бодитой үнэлээгүй байна.

Аудитаар нийт 257,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 85,6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгч ажиллалаа.




ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэлд зөвлөж байна.

1. Төсөл, хөтөлбөрийг удирдамжийн дагуу сонгон шалгаруулж, зорилтот бүлгийн иргэдийг бүрэн хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
2. Төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг сайжруулж, зорилтот түвшинг хангах.
3. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг чанаржуулж, үр дүнг бодитоор тооцох.

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



1. Эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэгийн хугацаандаа төлөгдөөгүй үлдэгдэл 85'585'000 төгрөгийг Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гийн 100070037010 дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэл, нягтлан бодогч Б.Золзаяа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
В.ЦЭНГЭЛМАА
АХЛАХ АУДИТОР
Б.ДЭЛГЭРМАА
АУДИТОР
Я.ЗОРИГ

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.МӨНХГЭРЭЛ
НЯГТЛАН БОДОГЧ
Б.ЗОЛЗАЯА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж зөвснө дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 16

Чайнсан хой

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас олгож буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн актыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэлд хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

11 054

Аймгийн Тэргүүлэх аудиторын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн /6/ тоот тушаалын хавсралт




Төлбөрийн актын жагсаалт

2018.06.29

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн актын утга	Мөнгөн дүн
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	ДОА-2018-01-ГА	Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг хугацаандаа төлөөгүй	85585000,0
	Нийт дүн			85585000,0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР  В.ЦЭНГЭЛМАА

БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  Б.ДЭЛГЭРМАА

АУДИТОР  М.УХААНБИЛЭГ

АУДИТОР  Я.ЗОРИГ